



# ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

2025 оны 08 дугаар сарын 19  
№33 (1378)

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН  
ТАМГЫН ГАЗАР

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН  
ТАМГЫН ГАЗАР



**ГАРЧИГ**

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ**

210.	Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөө багтах тухай	Дугаар 48	1583
------	---	-----------	------





## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2025 оны 05 дугаар  
сарын 29-ний өдөр

Дугаар 48

Улаанбаатар  
хот

### Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөө батлах тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 7 дахь заалт, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэг, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.3 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.“Монгол Улсын хөгжлийн 2026 онд баримтлах бодлогын тэргүүлэх чиглэл”-ийг 1 дүгээр хавсралтаар, “Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөө”-г 2 дугаар хавсралтаар, “Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөөний хяналт-шинжилгээ, үнэлгээний үзүүлэлт”-ийг 3 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2.Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөөг баталсантай холбогдуулан дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /Л.Оюун-Эрдэнэ/-т даалгасугай:

1/Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөөнд туссан улсын төсвийн эх үүсвэрээр санхүүжүүлэх шаардлагатай төсөл, арга хэмжээг Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хуулийн төсөлд тусгах;

2/Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөөнд төр, хувийн хэвшлийн түншлэл болон гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр тусгасан төсөл, арга хэмжээний бэлтгэл ажлыг хангаж ажиллах;

3/Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөөний биелэлтийг 2026 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн зохион байгуулж, биелэлтийг нэгтгэн гаргаж, Улсын Их Хуралд танилцуулах.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хороо /Р.Сэддорж/-нд даалгасугай.

4.Энэ тогтоолыг 2026 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**Д.АМАРБАЯСГАЛАН**





## МОНГОЛ УЛСЫН ХӨГЖЛИЙН 2026 ОНД БАРИМТЛАХ БОДЛОГЫН ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛ

“Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөө”-ний төслийг боловсруулах явцад буюу 2025 онд гадаад эрсдэлээс үүдэлтэй эдийн засаг дахь сөрөг нөлөөлөл хүчтэй байна. Тухайлбал, худалдааны дайн, геополитикийн хурцадмал байдал, БНХАУ-ын эдийн засгийн удаашрал зэрэг эрсдэлийн нөлөөгөөр дэлхий дахинд үүсээд буй тодорхой бус, эргэлзээтэй байдал нь КОВИД-19 цар тахлын үетэй ижил түвшинд хүрч нэмэгдээд байна. Улмаар манай улсын экспортын орлогыг бүрдүүлдэг гол бүтээгдэхүүн болох нүүрсний үнэ 2025 оны эхний улирлын байдлаар өмнөх оны мөн үеэс 40 орчим хувиар унаж, нийт экспортын орлого 17 хувиар, улсын нэгдсэн төсвийн нийт орлого 16 хувиар буурлаа. Түүхий эдийн үнэ буурсны улмаас бий болсон энэ нөхцөл байдал 2025, 2026 он дамжин үргэлжлэх төлөвтэй байна.

Хэдийгээр гадаад таагүй нөхцөл байдал үргэлжилж байгаа хэдий ч Монгол Улсын Их Хурлаас баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-т тусгагдсан томоохон төслүүдийг хөрөнгө оруулалт болон бизнесийн орчныг сайжруулах замаар оновчтой төлөвлөж үе шаттай хэрэгжүүлснээр эдийн засгийн өсөлтийг 6 хувиас дээш түвшинд хадгалах боломжтой.

“Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө”-ний төслийг боловсруулах үед уул уурхайн гол бараа, бүтээгдэхүүний үнэ унах эрсдэлийг<sup>1</sup> тооцсон бөгөөд сөрөг нөлөөллийг харьцангуй бага байлгах хүрээнд хил, гаалийн нэвтрүүлэх чадварыг сайжруулж, уул уурхайн бүтээгдэхүүний экспортын биет хэмжээг нэмэгдүүлэх, цаашилбал экспортыг төрөлжүүлэх тодорхой ажлыг хэрэгжүүлсэн.

Засгийн газраас түүхий эдийн үнийн савлагаа болон ган, зуд зэрэг байгаль, цаг уурын эрсдэл, нийлүүлэлтийн гаралтай инфляцын дарамт, эрчим хүчний хязгаарлагдмал нөөц, хилийн боомтууд дахь тээвэрлэлт, логистикийн саатал зэрэг болзошгүй эрсдэлийн нөлөөллийг урьдчилан тооцон, сөрөг үр дагаврыг бууруулахад чиглэсэн арга хэмжээг бодлогын хүрээнд авч хэрэгжүүлж байна. Тухайлбал, хүн амын хүнсний хангамжийг сайжруулах зорилгоор хөдөө аж ахуйн салбарт “Хүнсний хувьсгал” хөтөлбөр, хөнгөн үйлдвэрлэлийг дэмжих хүрээнд “Цагаан алт” хөдөлгөөнийг тус тус хэрэгжүүлсэн. Мөн уул уурхайн салбарт нүүрс баяжуулах болон зэс, гангийн үйлдвэрийг үйлдвэрлэл, технологийн паркийн хэлбэрээр

<sup>1</sup> 2024 оны байдлаар манай улсын дотоодын нийт бүтээгдэхүүний 28 хувь, экспортын орлогын 94 хувь, төсвийн орлогын 32 хувь нь уул уурхайн салбараас бий болж байна.



хөгжүүлэх чиглэлээр тодорхой ажил хийгдэж, эрчим хүчний салбарт хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, эрчим хүчний нийлүүлэлтийг сайжруулах зорилгоор эрчим хүчний зах зээлийг үе шаттайгаар либералчлах үйл явц эхэлж байна. Түүнчлэн, хилийн боомтуудад тээвэрлэлт, логистикийн саатал үүсэхээс урьдчилан сэргийлэх зорилгоор зохион байгуулалтын арга хэмжээ авч зам, талбайн өргөтгөлийн ажлыг хийж гүйцэтгэж байна.

Монгол Улсын хөгжлийн 2026 онд баримтлах бодлогын тэргүүлэх чиглэл нь “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-т тодорхойлсон “Бүсчилсэн хөгжлийн бодлого”, “Хүний хөгжлийн бодлого”, “Эдийн засгийн бодлого”, “Хүний эрхийг дээдэлсэн засаглалын бодлого” зэрэг үндсэн 4 бодлогын тэргүүлэх чиглэлийг үргэлжлүүлнэ.

**“ХҮН ТӨВТЭЙ”** хөгжлийн үзэл санаанд нийцсэн **“ЭДИЙН ЗАСГИЙН ЭРХ ЧӨЛӨӨГ ЦОГЦЛООХ”**-ыг зорьж эдийн засгийн эрх чөлөөний реформ, төсвийн зардлын реформ, төрийн албаны реформ, үндэсний баялгийн сан, төрийн өмчит компанийн засаглалын реформыг хэрэгжүүлнэ.

2026 онд нэн шаардлагатай салбарын реформ, тэргүүлэх ач холбогдолтой хөгжлийн 14 мега төслийг эрчимжүүлж, макро эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангаж, бизнесийн үйл ажиллагаанд оролцох төрийн оролцоог багасгах замаар ядуурлыг бууруулж, эдийн засгийн эрх чөлөөний реформыг хэрэгжүүлнэ. Үүнд:

### **Эдийн засгийн эрх чөлөөний реформ**

-Бизнесийн үйл ажиллагааг зохицуулж байгаа хууль тогтоомж, татварын орчны шинэчлэлийг хийж, төрийн үйлчилгээний цахимжилтыг эрчимжүүлж, Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулна.

-Хөрөнгө оруулалтыг хязгаарласан, хаасан зохицуулалтыг багасгаж, ялгамжтай байдлыг арилгах, оролцогчдын хууль ёсны эрх ашгийг хамгаалах, шинжлэх ухаан, гарааны бизнес, өндөр технологи, инновацыг дэмжих бодлого, хөшүүргийг тодорхойлох замаар хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлнэ.

-Стратегийн түнш болон томоохон зах зээлтэй улс орнуудтай эдийн засгийн хамтын ажиллагаа, түншлэл, чөлөөт худалдааны хэлэлцээрүүдийг дотоодын бизнес эрхлэгчид, хэрэглэгчдийн эрх ашигт нийцүүлэн байгуулах ажлыг үргэлжлүүлнэ.

### **Төсвийн зардлын реформ**



-Төсвийн урсгал зардлыг бууруулж, дотоодын нийт бүтээгдэхүүний 24 хувиас хэтрүүлэхгүй байна.

-Процессын дахин инженерчлэлийг хийж, төрийн үйлчилгээг хялбар, хүн төвтэй, про-актив хандлагаар эрчимжүүлнэ.

### **Төрийн албаны реформ**

-Төрийн албаны шинэчлэлийг хийж, чиг үүргийн давхардлыг арилгах зорилгоор багш, эмч нараас бусад төрийн албан хаагчдын тоог 9 хувиар бууруулах замаар чадварлаг, цомхон, бүтээмжид суурилсан төрийн албыг бэхжүүлнэ.

-Төрийн байгууллагуудын чиг үүрэгт иж бүрэн шинжилгээ хийсний үндсэн дээр зарим чиг үүргийг хувийн хэвшилд шилжүүлэх замаар төрийн бүтээмжийг дээшлүүлж, төрийн худалдан авалтад хиймэл оюуныг ашиглан ил тод байдлыг сайжруулж, үр ашгийг нэмэгдүүлнэ.

### **Үндэсний баялгийн сан, төрийн өмчит компанийн засаглалын реформ**

-Төрийн өмчит компаниудын реформыг эрчимжүүлж, зардлыг 15 хувиар бууруулна.

-Төрийн өмчит компаниудын бүтээмжийг 30 хувиар сайжруулна.

-Төрийн өмчит компаниудын хөрөнгийн удирдлагыг сайжруулж, хөдлөх, үл хөдлөх хөрөнгийн ашиглалтыг нэмэгдүүлж, үр ашиг, өгөөж, ашигт ажиллагааг сайжруулна.

-Баялгийн санг арвижуулж, хайгуулын болон ашиглалтын түвшнийг нэмэгдүүлж, геологийн нөөцийг өсгөн, стратегийн ордуудыг эдийн засгийн эргэлтэд оруулах цогц арга хэмжээг хэрэгжүүлнэ.

Дээрх бодлогын тэргүүлэх чиглэлийг амжилттай хэрэгжүүлснээр 2026 онд эдийн засгийн өсөлтийг 6.0 хувьд хадгалж, 1 хүнд ногдох дотоодын нийт бүтээгдэхүүнийг 8,090 ам.долларт хүргэж, ядуурлын түвшинг 5 хувиар бууруулна.

### **Нэг.Бүсчилсэн хөгжлийн бодлого**

Бүсчилсэн хөгжлийн бодлого, хууль, эрх зүйн орчин, тогтолцоог боловсронгуй болгож, эдийн засгийн эрх чөлөөний реформыг бүсийн онцлогт нийцүүлэн хэрэгжүүлнэ. Бүсийн зөвлөлийн өргөтгөсөн

хуралдаанаас гарсан санал, дүгнэлт, Засгийн газрын шийдвэрийг бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалтай уялдуулан хэрэгжүүлнэ.

Хөдөө аж ахуй, мал аж ахуй, аялал жуулчлал, аж үйлдвэр, хүнс, худалдаа, эрчим хүч, үйлдвэрлэл, үйлчилгээний салбарыг кластер хэлбэрээр хөгжүүлж, хувийн хэвшлийн оролцоонд тулгуурлан экспортыг дэмжсэн үйлдвэрлэл, технологийн паркийг байгуулах замаар бүсийн онцлог, давуу тал, нөөц боломж, эдийн засгийн тэргүүлэх чиглэлтэй уялдуулан хөгжүүлнэ.

### **1.1.Бүсчилсэн хөгжлийн бодлого, хууль, эрх зүйн орчин, тогтолцоог боловсронгуй болгоно:**

1.1.1.Бүсчилсэн хөгжлийн удирдлага, зохицуулалтын тогтолцоог сайжруулна.

1.1.2.Бүсийн ялгаатай татвар, санхүүгийн бодлогыг тодорхойлж, хэрэгжүүлнэ.

1.1.3.Бүсүүдийн нөөц, онцлог, давуу талд тулгуурлан бүс тус бүрийн хөгжлийн хөтөлбөрийг тодорхойлно.

1.1.4.Бүс, орон нутгийн тээвэр, логистикийн оновчтой сүлжээ байгуулж, хот, хөдөөгийн хөгжлийн тэнцвэртэй байдлыг хангана.

1.1.5.Бүсийн зөвлөлд нийгмийн түншлэгч байгууллагууд, Үйлдвэрчний эвлэл, ажил олгогч байгууллагын оролцоог хангаж, Бүсийн хөдөлмөр, нийгэм, эдийн засгийн хэлэлцээр байгуулна.

### **1.2.Бүс нутгийн эдийн засгийн чадавхыг нэмэгдүүлж, бүсчилсэн хөгжлийн реформыг хэрэгжүүлж, дэд бүтцийг хүртээмжтэй болгоно:**

1.2.1.Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалд нийцүүлэн, эдийн засгийн төрөлжилт, өндөр технологи, инновацын суурийг бүрдүүлэх төвүүдийг байгуулах ажлыг эхлүүлнэ.

1.2.2.Шинэ суурьшлын бүс байгуулах ажлыг эрчимжүүлж, дагуул хотуудын хатуу, зөөлөн дэд бүтцийн бүтээн байгуулалт, эдийн засгийн бүсчилсэн хөгжлийг дэмжинэ.

1.2.3.Бүсийн дэд бүтэц, бүтээн байгуулалтад гадаад, дотоодын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, тээвэр, логистик, эрчим хүч, дулааны станц байгуулах, агаарын тээвэр, авто зам, төмөр замын сүлжээг өргөжүүлнэ.

1.2.4.Орон нутгийн хөгжлийн төвүүдэд бүс нутгийн онцлогт суурилан хөдөө аж ахуй, хүнсний үйлдвэрлэл, үйлчилгээ, худалдааг кластераар хөгжүүлж, хувийн хэвшил болон хоршоодыг дэмжих замаар үйлдвэрлэл, технологийн паркийг бүсчлэн байгуулна.

1.2.5.“Шинэ хоршоо-Чинээлэг малчин” арга хэмжээг эрчимжүүлж, анхан шатны боловсруулалт хийх дундын хоршоог сумдаар бүсчлэн байгуулж, бүсийн онцлогт тохирсон газар зүйн заалттай бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн чиглэлд “Шинэ хоршоо 2.0” арга хэмжээг хэрэгжүүлнэ.

1.2.6.Улаанбаатар хотын “Шинэ их тойруу” хурдны зам, хөнгөн төмөр замын тээвэр /LRT/ барих төслийн бэлтгэл ажлыг хангана.

1.2.7.“Өөдөө тэмүүлэх Монгол” ган татлагат гүүрэн байгууламжийг барих бэлтгэл ажлыг хангана.

1.2.8.Тусгай замын автобус (BRT)-ны сүлжээ байгуулах төслийн бэлтгэл ажлыг хангана.

### **Хоёр.Хүний хөгжлийн бодлого**

Тогтвортой хөгжлийн зорилгын хэрэгжилтийг эрчимжүүлж, “Хөгжлөөс хэнийг ч орхигдуулахгүй байх” зарчмыг баримтлан, хүн бүрд саадгүй, хүртээмжтэй, аюулгүй, эрүүл орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлж, хөдөлмөрийн зах зээлд өрсөлдөх чадварыг хамгаалах, дэмжих бодлогыг хэрэгжүүлж, ядуурал, тэгш бус байдлыг бодитой бууруулж, чинээлэг, баялагтаа эзэн, эрдэм боловсролтой, эрүүл монгол хүнийг хөгжүүлнэ.

Чингис хаан Үндэсний баялгийн сангаар (Ирээдүйн өв сан, Хуримтлалын сан, Хөгжлийн сан) дамжуулан ирээдүйд хөрөнгө оруулалт хийх, эрүүл мэнд, боловсрол, орон сууцжуулалт, хуримтлалын хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.

**2.1.“Эрдэм боловсролтой Монгол хүн”-ийг хөгжүүлж, тэгш, хүртээмжтэй, чанартай боловсролын нэгдсэн тогтолцоог бэхжүүлнэ:**

2.1.1.2026 оныг “Боловсролыг дэмжих жил” болгон зарласантай холбогдуулан боловсролын чанар, хүртээмж, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлнэ.

2.1.2.Сургууль, цэцэрлэгийн тоог (108 сургууль, 95 цэцэрлэг) нэмэгдүүлж, бүлэг дүүргэлтийг стандарт түвшинд хүргэнэ.



2.1.3. “Хамгийн сайн цэцэрлэг, сургууль-гэрт ойр” хөтөлбөрийг хэрэгжүүлж, хот, хөдөөгийн боловсролын чанарын ялгааг бууруулна.

2.1.4. Дотоодын болон олон улсын их, дээд сургуулиудын хооронд кредит шилжүүлгийн тогтолцоог боловсронгуй болгоно.

2.1.5. Гадаад, дотоодын докторын түвшинд суралцаж байгаа оюутнуудад зориулсан тэтгэлгийн тогтолцоо бий болгоно.

2.1.6. Дэлхийн шилдэг багш, профессоруудыг Монголд ажиллах нөхцөлийг бүрдүүлнэ.

2.1.7. Сургалтын чанар, багшийн ур чадвар, төгсөгчийн хөдөлмөр эрхлэлт зэрэг үзүүлэлттэй уялдуулан үнэлгээний системийг сайжруулна.

2.1.8. Улаанбаатар хотын сургууль, цэцэрлэгийн бүлэг дүүргэлт, ээлжийг багасгаж, аймаг, сумын сургууль, цэцэрлэгийн дэд бүтэц, сургалтын орчин, хэрэглэгдэхүүний хүртээмжийг нэмэгдүүлнэ.

2.1.9. Сайн багш таны дэргэд-Багшийн 3 тулгуурт бодлогын арга хэмжээг үргэлжлүүлж, багшийн чанар, хангалтыг нэмэгдүүлж, тогтвор суурьшилтай ажиллах нөхцөлийг бүрдүүлнэ.

2.1.10. Эдийн засгийн тэргүүлэх чиглэл, бүсчилсэн хөгжлийн зорилттой уялдуулан ахлах сургууль, мэргэжлийн болон техникийн боловсрол, дээд боловсролын сургалтын байгууллагыг төрөлжүүлж, хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, шаардлагад нийцсэн хүний нөөцийг бэлтгэж, сургана.

2.1.11. Их өгөгдөл, хиймэл оюунд суурилсан цахимжсан боловсролын тогтолцоог тогтвортой хөгжүүлнэ.

2.1.12. Мэргэжлийн болон техникийн боловсролын салбарт хөдөлмөрийн зах зээлийн эрэлттэй уялдсан сургалт, дадлагын чанарыг сайжруулж, төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааг өргөжүүлнэ.

2.1.13. Хөдөлмөрийн зах зээлтэй уялдсан боловсролын тогтолцоо руу шилжихэд ахлах ангийн сурагчдад мэргэжлийн чиг баримжаа олгож, малчин өрхийн хүүхдүүдэд зориулсан төрөлжсөн сургуулийг бий болгох бодлого хэрэгжүүлнэ.

2.1.14. Өрсөлдөх чадвартай дээд боловсрол төсөл хэрэгжүүлнэ.



2.1.15.Сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээнд хамрагдаж чадахгүй хүүхдийг гэр бүл, орон нутгийн онцлог байдалд нийцүүлэн, сургуулийн өмнөх боловсрол эзэмшүүлэх бэлтгэл ажлыг хангана.

2.1.16.Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдыг гадаад болон дотоодын тэмцээн, уралдаанд оролцох боломжоор хангаж, дэмжлэг үзүүлэн, санхүүжилтийг нэмэгдүүлнэ.

2.1.17.Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын сургуулийн багш нарыг Боловсролын зээлийн сангийн тэтгэлгээр гадаадад сургаж, мэргэшүүлнэ.

2.1.18.Багш ажилчдын цалин хөлс, нийгмийн баталгааны асуудлыг тэргүүн ээлжид сайжруулна.

2.1.19.“Малчин залуу-манлайлагч” арга хэмжээг үргэлжлүүлж, малчид хоршоологчдод мал аж ахуйн гаралтай түүхий эд, бэлтгэлийн үйл ажиллагаанд бүс нутаг, олон улсын стандартыг нэвтрүүлэхэд шаардлагатай мэдлэг эзэмших, орчин үеийн тоног төхөөрөмж ашиглах үр чадварыг гадаад улсад олгоход чиглэгдсэн төсөл хэрэгжүүлнэ.

## **2.2.“Эрүүл Монгол хүн”-ийг хөгжүүлнэ:**

2.2.1.Хүн амд зонхилон тохиолдож байгаа зүрх судас, хавдрын өвчлөлийг эмчилгээний шинэ технологи, туршлагыг нэвтрүүлэх замаар бууруулах цогц бодлогыг хэрэгжүүлнэ.

2.2.2.Гарцад суурилсан санхүүжилтийн шинэчлэлийг бэхжүүлэх хүрээнд тусламж, үйлчилгээ худалдан авагчийн чанар, төлбөрийн хяналтыг хиймэл оюун ашиглан боловсронгуй болгож, эрүүл мэндийн даатгалын санхүүжилтийн үр ашгийг сангийн актуар тооцоолол дээр суурилан нэмэгдүүлнэ.

2.2.3.Орон нутгийн нэгдсэн эмнэлгийн чадавхыг бэхжүүлж, яаралтай болон түргэн тусламжийн үйлчилгээг сайжруулж, эмнэлгийн тусламж, үйлчилгээний төвлөрлийг сааруулж, иргэд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ авахад учрах хүлээгдэл, чирэгдлийг бууруулна.

2.2.4.Төр, хувийн хэвшлийн үр ашигтай, үр дүнтэй түншлэлийг бий болгох хүрээнд эрүүл мэндийн салбарын төсөв дэх олон улсын хөтөлбөр, гадаадын зээл тусламжаар санхүүжүүлэх хөрөнгө оруулалтын үр дүнг шалгуур үзүүлэлтээр үнэлдэг тогтолцоог бүрдүүлж, үр дүнг иргэдэд нээлттэй, ил тод тайлагнана.



2.2.5.Эрүүл мэндийн салбарын их өгөгдлийг бий болгож, тусламж үйлчилгээнд хиймэл оюун ашиглана.

2.2.6.Хүн амын амьдралын хэв маяг, зан үйл, орлого, боловсролын түвшин, орчин, ахуйн нөхцөл, соёл уламжлал зэрэг нийгэм, эдийн засгийн хүчин зүйлсийг харгалзан, эрүүл мэндийн тэгш бус байдлыг арилгахад нөөцийг үр ашигтай хуваарилах замаар нийгмийн эрүүл мэндийн арга хэмжээг оновчтой тодорхойлж, үр дүнг шалгуур үзүүлэлтээр үнэлснээр хүн амын бие бялдрын хөгжлийн түвшнийг нэмэгдүүлнэ.

2.2.7.Эрэгтэйчүүдийн эрүүл мэндийг дэмжих, тэдэнд хүрэх тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулан, гэнэтийн осол, гадны шалтгаант нас баралтыг бууруулж, дундаж наслалтыг нэмэгдүүлнэ.

2.2.8.Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний нэгдсэн тогтолцоо бүрдүүлэх зорилгоор орон нутагт Нийгмийн эрүүл мэндийн төв байгуулна.

2.2.9.Нийтийн эрүүл мэндийг дэмжих төлөвлөгөө /2026-2036/-г батална.

### **2.3.Хүн төвтэй нийгмийн үйлчилгээг нэвтрүүлнэ:**

2.3.1.Гэр бүлд ээлтэй, хүн төвтэй, хүн амын бүлгүүдэд чиглэсэн үйлчилгээг хөгжүүлж, нийгмийн халамжийн үйлчилгээний тогтолцооны цогц шинэчлэл хийж, их өгөгдөл, хиймэл оюуныг ашиглан иргэн бүрийн хэрэгцээ, шаардлагад нийцсэн нийгмийн үйлчилгээг үе шаттай нэвтрүүлнэ.

2.3.2.Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээний хүрээнд зорилтот өрх, иргэнийг хөгжүүлэх, чадавхжуулах, бие даан амьдрахад нь дэмжлэг үзүүлэх үйлчилгээг шинээр нэвтрүүлнэ.

2.3.3.Хүүхэд хамгааллын кейс менежмент, нийгмийн ажлын мэргэжлийн удирдлагыг хөгжүүлж, төрийн бүх албан хаагчдыг хүүхэд хамгааллын болон хүний эрхийн цахим сургалтад хамруулж, хүүхэд хамгааллын үйлчилгээг хүүхэд бүрд хүргэнэ.

2.3.4.Асрахуйн эдийн засгийг дэмжиж, ахмад настны асаргааны хувилбарт үйлчилгээг хөгжүүлж, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, хүүхдийг асарч байгаа иргэний хөдөлмөр эрхлэх боломжийг нэмэгдүүлнэ.

2.3.5.“Цалинтай эх, эцэг” нийгмийн хамгааллын бодлогыг олон улсын жишигт нийцүүлж, боловсронгуй болгоно.

2.3.6. Хөгжлийн бэрхшээлтэй хүнд хүртээмжтэй хөгжлийн цогц үйлчилгээний төвийг аймгуудад байгуулж, хөгжлийн бэрхшээлийн үйлдлийн чадамжийг тогтоох олон улсын аргачлалыг үе шаттайгаар нэвтрүүлж, саадгүй байдал, хүртээмжийг нэмэгдүүлж, нийгэмд тэгш оролцох боломжийг бүрдүүлнэ.

2.3.7. Орчны болон хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн эрсдэлийг нийгмийн түншлэгч Үйлдвэрчний эвлэл, ажил олгогчдын оролцоонд тулгуурлан бууруулна.

2.3.8. Гэр бүлийн цогц хөгжлийг дэмжих төв байгуулна.

2.3.9. Эмч, эмнэлгийн ажилтны цалин хөлсийг жил бүр нэмэгдүүлнэ.

#### **2.4. Хөдөлмөрийн зах зээлд өрсөлдөх чадварыг хамгаалах, дэмжих бодлогыг хэрэгжүүлнэ:**

2.4.1. Хүний нөөц, ур чадварын шилжилтийн стратегитай уялдуулан бүтээмжийг нэмэгдүүлнэ.

2.4.2. Хүн амын бүлгүүдийн онцлогт нийцсэн ур чадварт сургах замаар хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлж, ядуурлыг бууруулах бодлого баримтална.

2.4.3. Хиймэл оюун, өндөр технологийн мэргэжилтэн бэлтгэж, хөдөлмөрийн зах зээлийн эрэлтэд шаардлагатай ур чадварт сургана.

#### **2.5. Нийгмийн баталгааг хангана:**

2.5.1. Чингис хаан Үндэсний баялгийн сангийн Ирээдүйн өв сангаар дамжуулж олон улсын зах зээлд хөрөнгө оруулалт хийж, Хуримтлалын сангаар дамжуулж эрүүл мэнд, боловсрол, орон сууцны зориулалтаар дэмжлэг үзүүлж, Хөгжлийн сангаар дамжуулж урт, дунд хугацааны хөгжлийн бодлогын баримт бичигт туссан эдийн засаг, нийгмийн үр өгөөж бүхий хөгжлийн төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг үргэлжлүүлнэ.

2.5.2. Нийгмийн даатгалын сангийн засаглалыг сайжруулж, санхүүгийн тогтвортой байдлыг бэхжүүлж, хөрөнгийн менежментийг үе шаттайгаар ил тод болгож, нийгмийн даатгалын хамрах хүрээг өргөжүүлнэ.

2.5.3. Хагас хуримтлалын тогтолцоонд шилжих шинэчлэлийг үргэлжлүүлж, тэтгэврийн даатгалын шимтгэлийн 2 хувийг нэрийн дансанд хуримтлуулна.

2.5.4.Хөдөлмөрийн бүтээмж, цалин хөлс, тэтгэврийн хэмжээг инфляцын түвшинтэй уялдуулж нэмэгдүүлнэ.

## **2.6.Төлбөрийн чадварт нийцсэн орон сууцны хүртээмжийг нэмэгдүүлнэ:**

2.6.1.“Миний түрээсийн орон сууц” хөтөлбөрийг үргэлжлүүлж, “Миний сонголт орон нутаг”, “Миний амины орон сууц” хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.

2.6.2.Нийслэл, орон нутагт эрчим хүчний хэмнэлттэй, байгальд ээлтэй амины болон нийтийн зориулалттай орон сууц барих таатай орчныг бүрдүүлнэ.

2.6.3.Иргэдийн төлбөрийн чадварт нийцсэн, инженерийн бүрэн хангамжтай, эрүүл, аюулгүй орчин бүхий 150,000 айлын орон сууцныг нийслэл Улаанбаатар хот болон хөдөө орон нутагт хүртээмжтэйгээр барина.

## **Гурав.Эдийн засгийн бодлого**

“Хүн төвтэй” хөгжлийн үзэл санаанд нийцсэн “Эдийн засгийн эрх чөлөө”-г цогцлооно. Шинжлэх ухаан, инновац, хиймэл оюун, дэвшилтэт технологид суурилсан мэдлэг, оюуны өмчийг эдийн засгийн эргэлтэд оруулах бодлогоор дэмжиж, оюуны өмчийн үнэлэмжийг нэмэгдүүлнэ.

Тогтвортой хөгжлийн зорилгыг хэрэгжүүлж, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлж, зах зээл дэх төрийн оролцоог бууруулж, макро эдийн засгийн тогтвортой байдлыг хангана.

Жижиг, дунд, бичил бизнесийг дэмжих урт хугацаатай, бага хүүтэй зээлийн бүтээгдэхүүний төрөл, хүртээмжийг нэмэгдүүлнэ.

Санхүүгийн салбарын шинэчлэлийг эрчимжүүлж, цахим эдийн засгийн эзлэх хувийг нэмэгдүүлснээр дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хиймэл оюуны хувь нэмрийг бодитойгоор өсгөж, эдийн засгийн урт хугацааны тогтвортой хөгжлийг хангана.

## **3.1.Шинжлэх ухаан, инновац, хиймэл оюун, оюуны өмчийг тэргүүлэх салбар болгон хөгжүүлнэ:**

3.1.1.Шинжлэх ухаан, технологийн үйл ажиллагааны зардлыг үе шаттайгаар нэмэгдүүлж, дотоодын нийт бүтээгдэхүүний 0.5 хувьд хүргэж, шинжлэх ухаан, инновац, технологид суурилсан мэдлэгийн эдийн засгийн суурийг бэхжүүлнэ.



3.1.2.Дотоодын нийт бүтээгдэхүүнд мэдээллийн технологийн салбарын эзлэх хувийг нэмэгдүүлж, цахим эдийн засгийн шилжилтийг эрчимжүүлнэ.

3.1.3.Оюуны бүтээлийн үнэлэмжийг нэмэгдүүлж, шинэ бүтээл, оюуны өмч, судалгаа шинжилгээ, патент, шинэ технологийг эдийн засгийн эргэлтэд оруулж, салбаруудын бүтээмжийг нэмэгдүүлнэ.

3.1.4.Үндэсний судалгаа, хөгжүүлэлтийн төсөл, эрдэм шинжилгээний байгууллагын судалгааны үндсэн чиглэлийн үйл ажиллагааг дэмжиж, санхүүжилтийг нэмэгдүүлнэ.

3.1.5.Хүний нөөцийн нэгдсэн хөтөлбөрийн хүрээнд гадаад улсад мэргэжил эзэмшсэн, нарийн мэргэжлийн инженер, академик ажил эрхэлж байгаа хүний нөөцөд чиглэсэн /Brain Drain-Brain Gain/ тусгайлсан хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.

3.1.6.Шинжлэх ухаан, технологийн салбарт төр, хувийн хэвшлийн түншлэлийг дэмжсэн хууль, эрх зүй, татварын таатай орчныг бүрдүүлж, адилтгах санхүүжилт /Matching fund/-ийн арга хэмжээг хэрэгжүүлнэ.

3.1.7.Инновацийн хөрөнгө оруулалтын санг байгуулж, технологи дамжуулах хөтөлбөрийг хэрэгжүүлж, инновацийн төсөл, арга хэмжээг дэмжинэ.

3.1.8.Үндэсний супер компьютерын тооцоолох төв болон үндэсний эрдэм шинжилгээний бүтээлийн нэгдсэн сан /MORI/-гийн платформыг олон улсын жишигт нийцүүлэн хөгжүүлнэ.

3.1.9.Олон улсын зах зээлд өрсөлдөх шинжлэх ухаан, технологийн тэргүүлэх чиглэл, хиймэл оюун, инновац, оюуны өмчийн гарааны бизнесийг дэмжих санхүүжилт, хөрөнгө оруулалтын орчныг бүрдүүлэн шинжлэх ухааны паркийг хөгжүүлнэ.

3.1.10.Хиймэл оюуны экосистемийг бүрдүүлж, төр, хувийн хэвшлийн түншлэл, эрдэм шинжилгээний байгууллагуудын хамтын ажиллагааг бэхжүүлж, инновац, дэвшилтэт технологийн эрх зүйн болон зохицуулалтын орчныг бүрдүүлж, судалгаа хөгжүүлэлтийг нэмэгдүүлнэ.

3.1.11.Хувийн хэвшлийн судалгаа хөгжүүлэлтийг татварын бодлогоор дэмжинэ.

### **3.2.Экспортын бүтээгдэхүүн, үйлчилгээг нэмэгдүүлнэ:**

3.2.1.Эдийн засгийн коридорын бүтээн байгуулалтыг эрчимжүүлж, дамжин өнгөрөх худалдаа, тээвэр, логистик, үйлчилгээний экспортыг нэмэгдүүлнэ.

3.2.2.Хил холболтын төмөр зам, боомт, чөлөөт бүсийн бүтээн байгуулалтыг эрчимжүүлж, экспортыг нэмэгдүүлнэ.

3.2.3.Нэмүү өртөг шингэсэн уул уурхайн бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлж, үйлдвэрлэл, технологийн паркуудын бүтээн байгуулалтын ажлыг эрчимжүүлнэ.

3.2.4.“Малын эзэн-Үйлдвэрийн эзэн” хөтөлбөрийг хэрэгжүүлж, малын гаралтай түүхий эдийг дотооддоо боловсруулж, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүнийг гадаад зах зээлд экспортолно.

3.2.5.“Go Mongolia” арга хэмжээг үргэлжлүүлж, аялал жуулчлалын чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх замаар орлогыг нэмэгдүүлж, тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлнэ.

3.2.6.Нүүрс-хими, Кокс-химийн цогцолборыг ашиглалтад оруулах бэлтгэл ажлыг хангана.

3.2.7.Гангийн цогцолборыг ашиглалтад оруулах бэлтгэл ажлыг хангана.

3.2.8.Олон улсын эдийн засгийн хамтын ажиллагааны байгууллагын төлөөлөгчийн газрыг байгуулах бэлтгэл ажлыг хангана.

3.2.9.Лүнгийн 327 у/м гүүрийг 4 эгнээ болгон өргөтгөн шинэчилнэ.

3.2.10.Бичигт боомтод ачааны терминал байгуулах бэлтгэл ажлыг хангана.

3.2.11.Хавирга боомтод ачааны терминал байгуулах бэлтгэл ажлыг хангана.

3.2.12.Ховд аймгийн Булган сумын Булган боомтын үйл ажиллагааны хүчин чадлыг нэмэгдүүлэх бэлтгэл ажлыг хангана.

### **3.3.Хөрөнгийн зах зээл болон банк, санхүүгийн салбарын өрсөлдөх чадварыг сайжруулна:**

3.3.1.Хөрөнгийн зах зээлийг хөгжүүлж, үйлдвэрлэлийн салбарт санхүүжилтийн хүртээмжийг нэмэгдүүлж, шинэ эх үүсвэрүүдийг бүрдүүлнэ.



3.3.2.Банк, санхүү, даатгалын салбарын хууль, эрх зүйн орчныг шинэчилж, эрсдэлийн удирдлагыг сайжруулж, гадаадын банкны салбар, нэгж байгуулах нөхцөлийг бүрдүүлнэ.

3.3.3.Цахим банк, санхүүгийн үйлчилгээг нэвтрүүлнэ.

3.3.4.Ногоон санхүүжилтийг нэмэгдүүлж, байгаль орчинд ээлтэй, тогтвортой хөгжлийг дэмжсэн хөрөнгө оруулалт, санхүүгийн механизмыг хөгжүүлнэ.

3.3.5.Жижиг, дунд үйлдвэрлэл, хоршоог хөгжүүлэх чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгжийг дэмжиж, ажлын байрыг нэмэгдүүлнэ.

#### **3.4.Эдийн засгийн төрөлжилт, дэд бүтцийн бүтээн байгуулалтыг нэмэгдүүлнэ:**

3.4.1.Уул уурхайн бус экспортыг нэмэгдүүлэх, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний нэмүү өртөг шингэсэн үйлдвэрлэлийг дэмжинэ.

3.4.2.Орон сууцжуулалт, гэр хорооллын дахин төлөвлөлтийн төслийг үргэлжлүүлж, инженерийн шугам сүлжээг шинэчилнэ.

3.4.3.Өндөр технологид суурилсан ухаалаг тээврийн системийг нэвтрүүлж, хилийн боомтын ачаа эргэлт болон логистикийн хүчин чадлыг нэмэгдүүлнэ.

3.4.4.Гадаад худалдаатай холбоотой төрийн үйлчилгээг цахим хэлбэрээр үзүүлэх “Гадаад худалдааны цахим нэг цонх” системийг нэвтрүүлнэ.

3.4.5.Эрчим хүчний салбарын реформын хэрэгжилтийг эрчимжүүлж, сэргээгдэх эрчим хүч үйлдвэрлэлийг нэмэгдүүлж, дотоодын хэрэгцээг хангана.

3.4.6.“10,000 нарны дээвэр” хөтөлбөрийг төр, хувийн хэвшлийн түншлэл, олон улсын байгууллагын дэмжлэгтэйгээр хэрэгжүүлж эхэлнэ.

3.4.7.Тариалангийн дэвшилтэт технологийг нэвтрүүлж, ухаалаг технологид суурилсан газар тариаланг хөгжүүлэх “Атар-4 тариалангийн тогтвортой хөгжлийн аян”-ыг хэрэгжүүлж, хүнсний хангамжийг нэмэгдүүлнэ.

3.4.8. “Хүнсний хангамж, аюулгүй байдал” үндэсний хөдөлгөөнийг өрнүүлж, хүнсний сүлжээний үе шат бүрд стандартыг хангаж, итгэмжлэгдсэн, эрүүл ахуйн шаардлага хангасан хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлж, дотоодын хэрэгцээг хангаж, гадаад зах зээлд нийлүүлнэ.

3.4.9. Малын гаралтай түүхий эдийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэхэд чиглэсэн “Цагаан алт” хөдөлгөөнийг үргэлжлүүлж, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг дэмжиж, орлогыг нэмэгдүүлнэ.

3.4.10. “Атар-4 тариалангийн тогтвортой хөгжлийн аян”-ы хүрээнд баруун бүс нутгийн өмнөх түвшинд хүрч чадахгүй байгаа газар тариалан, гурилын үйлдвэрийг сэргээн хөгжүүлэхэд төрийн бодлогыг чиглүүлж, үйлдвэрлэл, хангалтыг нэмэгдүүлэх суурийг тавина.

3.4.11. Газар тариалангийн салбарт үрийн үйлдвэрлэл, чанарт тавих стандартыг онцгой анхаарч, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицсон өндөр ургац өгдөг, чанартай, баталгаат үрээр хангах үрийн аж ахуйнуудыг бэхжүүлэх дэмжлэг урамшууллын тогтолцоо нэвтрүүлнэ.

3.4.12. Хүн амын хүнсний гол нэрийн бүтээгдэхүүн, хүнсний түүхий эд улаан буудайн стратегийн нөөцийг бүрэн бүрдүүлнэ.

3.4.13. Малын гаралтай түүхий эд бэлтгэлийн үе шат бүрд стандарт нэвтрүүлж, мал аж ахуйн салбарын кластерын тогтолцоог бодлогоор дэмжин бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг нэмэгдүүлнэ.

3.4.14. Байдрагийн усан цахилгаан станц төслийг хэрэгжүүлэх бэлтгэл ажлыг хангана.

3.4.15. Байгалийн хий нийлүүлэх хоолой барих төслийн бэлтгэл ажлыг хангана.

### **3.5. Геологи хайгуул, олборлолт, боловсруулалт, баяжуулалтын ажлыг эрчимжүүлнэ:**

3.5.1. Өндөр технологийн түүхий эд болох газрын ховор элементийн /критикал минерал/ хайгуул, эрлийн ажлыг идэвхжүүлж, геологийн зураглалын чанар, нарийвчлалыг ахиулж, геохимийн шинжилгээ гүйцэтгэх чадавхыг бэхжүүлэн хайгуул, олборлолтын мэдээллийг ил тод, нээлттэй болгоно.

3.5.2. Геологийн шинжлэх ухааны хөгжил, судалгааг эрчимжүүлж, хайгуулын ажлыг өргөжүүлж, геологийн нөөцийг нэмэгдүүлж,



ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрлийн олголтыг эрчимжүүлнэ.

3.5.3. Үнэт, өнгөт, хар, ховор, холимог металл болон металл бус ашигт малтмалын эрэл, үнэлгээний ажлыг эрчимжүүлнэ.

3.5.4. Хүнд үйлдвэрлэлийг хөгжүүлж, нүүрс, зэс, төмрийн хүдэр баяжуулах, хайлуулах, боловсруулах үйлдвэрийг үе шаттайгаар байгуулж, ашиглалтад оруулна.

3.5.5. Эрдэс баялгийн салбарт хиймэл оюун, өндөр технологийг эрчимтэй нэвтрүүлнэ.

### **3.6. Байгалийн нөөцийн зохистой ашиглалтыг дэмжин орчны бохирдлыг бууруулна:**

3.6.1. Экосистемийг хамгаалах менежментийг сайжруулж, усны нөөцийг нэмэгдүүлэх томоохон төслүүдийг уялдуулан хэрэгжүүлнэ.

3.6.2. Агаар, орчны бохирдлыг бууруулах цогц арга хэмжээг хэрэгжүүлнэ.

3.6.3. Уур амьсгалын өөрчлөлтийг даван туулах зорилгоор эрх зүйн орчныг бүрдүүлж, санхүүжилтийн хөшүүргийг бий болгох замаар эдийн засгийн салбарыг уур амьсгалын өөрчлөлтөд тэсвэртэй, дасан зохицох чадвар бүхий ногоон хөгжилд чиглүүлнэ.

3.6.4. “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнийг үргэлжлүүлэн хэрэгжүүлж, ойн санг хамгаалах, нөхөн сэргээх ажлыг эрчимжүүлж, ойгоор бүрхэгдсэн талбайн хэмжээг нэмэгдүүлнэ.

3.6.5. Цөлжилттэй тэмцэх, гангийн үр нөлөөг бууруулах, бэлчээрийн газрын тогтвортой менежментийг сайжруулах бодлого, арга хэмжээг хэрэгжүүлнэ.

### **Дөрөв. Хүний эрхийг дээдэлсэн засаглалын бодлого**

Дэвшилтэт технологи, процессын дахин инженерчлэлийг хэрэгжүүлж, төрийн бүтээмжийг нэмэгдүүлэх замаар хүний эрх, эрх чөлөөг дээдэлсэн, авлигагүй, хүн төвтэй төрийн үйлчилгээг бий болгоно.

“Хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөр-2”-ыг хэрэгжүүлж, үндэсний сөрөн тэсвэрлэх чадавхыг бэхжүүлж, улсын батлан хамгаалах бодлогын үндсэн чиглэлийг тодорхойлж, аюулгүй байдлыг бататгаж,





гадаад харилцааны “Нэг цонх”-ны бодлого баримтлан, энхийг эрхэмлэсэн, нээлттэй, бие даасан олон тулгуурт гадаад бодлогыг тууштай баримтална.

#### **4.1.Төрийн бүтээмжийг нэмэгдүүлэх чиглэлээр процессын дахин инженерчлэлийг хэрэгжүүлнэ:**

4.1.1.Төрийн үйлчилгээний хурд, чанарыг сайжруулж, үр ашиггүй, давхардсан үйлчилгээг халж, цахим шийдлийг нэвтрүүлэх замаар зардлыг бууруулж, зорилтот хүн, хуулийн этгээдэд про-актив хэлбэрээр хүргэхээр дахин инженерчилнэ.

4.1.2.Хяналт шалгалтыг бизнесийн байгууллагын үйл ажиллагаанд нөлөөлөхгүй байдлаар зохион байгуулах, шаардагдах материалыг цахим хэлбэрээр, нийтийн мэдээллийн дэд бүтцээр дамжуулан, эрх бүхий байгууллага өөрөө олж авах тогтолцоог бүрдүүлнэ.

4.1.3.Төлөвлөлт-Төсөвлөлт-Хяналт, үнэлгээ /DME/-ний платформыг хөгжүүлж, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн нэгдсэн сан, тогтолцоо, процесс, санхүүжилтийн орчныг сайжруулна.

4.1.4.Хуулийн этгээд байгуулах, бизнес эхлүүлэх шат дамжлага, хүндрэл чирэгдлийг багасгаж, бизнесийн үйл ажиллагаанд шаардагдах зөвшөөрлийг хялбарчлан мэдээллийг ил тод, нээлттэй, шуурхай болгож “Зөвшөөрөл 2.0” системийг нэвтрүүлж төрийн оролцоог бууруулна.

4.1.5.Улсын хэмжээний тооллого, түүвэр судалгааг зохион байгуулах бэлтгэл ажлыг хангана.

4.1.6.Даргын эрх мэдлийг баталгаажуулсан байгууллагын хуулийг өөрчилж, иргэнд үйлчлэх албаны хууль болгон шинэчлэх ажлыг эрчимжүүлнэ.

4.1.7.Төрийн албан хаагчийг улс төрийн болон удирдлагын хууль бус шийдвэр, аливаа дарамт шахалтаас ангид байлгах эрх зүйн шинэчлэл хийнэ.

#### **4.2.Хүний эрх, эрх чөлөөг дээдэлнэ:**

4.2.1.Иргэдийн амар тайван, аюулгүй амьдрах орчныг бүрдүүлж, гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журмыг хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах ажлыг эрчимжүүлнэ.

4.2.2.Хүний эрх, эрх чөлөө, шударга ёс, үндэсний эв нэгдлийг хадгалан хамгаалах, эдийн засгийн өсөлтийг дэмжихэд чиглэсэн эрх зүйн тогтолцоог бэхжүүлнэ.



4.2.3.Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тогтолцоог бэхжүүлж, шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлнэ.

4.2.4.Хөгжлөөс хэнийг ч орхигдуулахгүй байх зарчмыг баримтлан хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг хөдөлмөр эрхлэх боломжийг бүрдүүлэхэд бодлогоор дэмжиж, зөрчигдөж буй эрхийг хамгаална.

4.2.5.Саадгүй байдал, хүртээмжийн тухай хуулийг батлуулж, хөгжлийн бэрхшээлтэй хүний тэгш, хүртээмжтэй дэд бүтцийн стандартыг албан байгууллага, орон сууц, худалдаа, үйлчилгээний байгууллагуудад мөрдүүлнэ.

#### **4.3.Үндэсний сөрөн тэсвэрлэх чадавхыг бэхжүүлнэ:**

4.3.1.Батлан хамгаалах тогтолцоог бэхжүүлж, хиймэл оюун, орчин үеийн техник, технологид суурилсан зэвсэгт хүчнийг хөгжүүлнэ.

4.3.2.Энхийг дэмжих ажиллагаа, улс орны бүтээн байгуулалтын үйл ажиллагаанд зэвсэгт хүчний оролцоог нэмэгдүүлж, олон улсад Монгол Улсын байр суурийг бэхжүүлнэ.

4.3.3.Цэргийн аж үйлдвэр, дэд бүтцийг хөгжүүлж, батлан хамгаалах бие даасан байдлыг хангаж, иргэдэд эх оронч үзлийг төлөвшүүлэх ажлыг зохион байгуулна.

4.3.4.Дэвшилтэт технологи, инновацад суурилсан гамшгаас хамгаалах эрт сэрэмжлүүлэх зарлан мэдээллийн нэгдсэн систем байгуулах, гамшгийн үеийн бэлтгэл, бэлэн байдлын хангалтыг нэмэгдүүлнэ.

4.3.5.Засгийн газраас хэрэгжүүлж буй мега төслүүдийн бүтээн байгуулалтын ажилд зэвсэгт хүчнийг оролцуулна.

#### **4.4.Шударга байдлын үзүүлэлтийг сайжруулна:**

4.4.1.“Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр”-ийн хэрэгжилтийн үр дүн, үр нөлөөг нэмэгдүүлж, Транспаренси Интернэйшнл олон улсын байгууллагын Авлигын төсөөллийн индексийн оноог сайжруулах нөхцөлийг бүрдүүлнэ.

4.4.2.Авлигаас урьдчилан сэргийлэх, авлигын гэмт хэргээс сэргийлэх энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх бодлого, эрх зүйн шинэчлэлийг эрчимжүүлнэ.



4.4.3. Бизнес эхлүүлэхэд гардаг хүндрэл, шат дамжлагыг бууруулж, эдийн засгийн үйл ажиллагаанд оролцох төрийн оролцоог багасгана.

4.4.4. Төрийн байгууллага, албан тушаалтны буруутай үйлдлээс хохирсон иргэд, бизнес эрхлэгчдийн хохирлыг шуурхай барагдуулах эрх зүйн орчныг бүрдүүлнэ.

#### **4.5. Дэвшилтэт технологид суурилсан цахим засаглалыг бэхжүүлнэ:**

4.5.1. Төрийн албаны цахим системийг хиймэл оюун, дэвшилтэт технологид суурилан хөгжүүлж, төрийн албаны их өгөгдлийн санг бүрдүүлж, төрийн бүтээмжийг нэмэгдүүлнэ.

4.5.2. Цахим дэд бүтцийг өргөжүүлж, хиймэл оюун бүхий төрийн үйлчилгээний нэгдсэн системээр төрийн үйлчилгээг иргэдэд шуурхай хүргэнэ.

4.5.3. “ХУР” мэдээлэл солилцооны системийг шинэчилж, тархмал бүтцэд шилжүүлнэ.

4.5.4. Кибер аюулгүй байдлын үндэсний стратегийг хэрэгжүүлнэ.

4.5.5. Хиймэл оюун, өндөр технологийн болон ногоон хөгжлийн шилжилт, хөдөлмөрийн зах зээл, хүний нөөцийн ур чадварын шилжилтийг эрчимжүүлэх стратеги төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд бодлогоор дэмжинэ.

4.5.6. Үндэсний хиймэл дагуул хөөрөгх бэлтгэл ажлыг хангана.

#### **4.6. Эрсдэлийн удирдлагын тогтолцоог нэвтрүүлнэ:**

4.6.1. Эрсдэлийн удирдлагыг төрийн байгууллагуудад үе шаттайгаар нэвтрүүлж, болзошгүй нөхцөл байдлаас урьдчилан сэргийлэх ажлыг эхлүүлнэ.

4.6.2. Гамшгийн эрсдэлийг бууруулах, даван туулах, сөрөн тэсвэрлэх чадавхыг нэмэгдүүлнэ.

4.6.3. Цахим шилжилтийн эрчимжүүлэлттэй холбогдуулан кибер халдлагаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах арга хэмжээг хэрэгжүүлнэ.

----oO----





– **veicināt mācību procesa uzlabošanu.**

– **veicināt mācību procesa uzlabošanu, īstenojot mācību programmas, kas nodrošina kvalitatīvu mācību procesu un veicina mācībspēku profesionālo izaugsmi.**

– **veicināt mācību procesa uzlabošanu, īstenojot mācību programmas, kas nodrošina kvalitatīvu mācību procesu un veicina mācībspēku profesionālo izaugsmi.**

– **veicināt mācību procesa uzlabošanu.**

– **veicināt mācību procesa uzlabošanu, īstenojot mācību programmas, kas nodrošina kvalitatīvu mācību procesu un veicina mācībspēku profesionālo izaugsmi.**

– **veicināt mācību procesa uzlabošanu, īstenojot mācību programmas, kas nodrošina kvalitatīvu mācību procesu un veicina mācībspēku profesionālo izaugsmi.**

– **veicināt mācību procesa uzlabošanu.**

– **veicināt mācību procesa uzlabošanu, īstenojot mācību programmas, kas nodrošina kvalitatīvu mācību procesu un veicina mācībspēku profesionālo izaugsmi.**

– **veicināt mācību procesa uzlabošanu, īstenojot mācību programmas, kas nodrošina kvalitatīvu mācību procesu un veicina mācībspēku profesionālo izaugsmi.**

– **veicināt mācību procesa uzlabošanu, īstenojot mācību programmas, kas nodrošina kvalitatīvu mācību procesu un veicina mācībspēku profesionālo izaugsmi.**

– **veicināt mācību procesa uzlabošanu, īstenojot mācību programmas, kas nodrošina kvalitatīvu mācību procesu un veicina mācībspēku profesionālo izaugsmi.**



МОНГОЛ УИХЫН ХУУЛЬ  
2025 он №33/1378/

**УИХЫН ХУУЛЬ**

УИХЫН ХУУЛЬ  
2025 он №33/1378/

УИХЫН ХУУЛЬ  
2025 он №33/1378/

УИХЫН ХУУЛЬ  
2025 он №33/1378/

УИХЫН ХУУЛЬ  
2025 он №33/1378/

УИХЫН ХУУЛЬ  
2025 он №33/1378/

УИХЫН ХУУЛЬ  
2025 он №33/1378/

УИХЫН ХУУЛЬ

УИХЫН ХУУЛЬ  
2025 он №33/1378/

УИХЫН ХУУЛЬ

УИХЫН ХУУЛЬ  
2025 он №33/1378/

УИХЫН ХУУЛЬ  
2025 он №33/1378/



















дэманстрацыя адначасна адваротнага змянення ўзросту і вагі ў індывідуумаў, якіх характэрна пераходзіць ад аднаго стадыі да іншай (напрыклад, ад аднаго стадыі да іншай). Змяненні вагі і узросту звычайна пераходзяць ад аднаго стадыі да іншай (напрыклад, ад аднаго стадыі да іншай).

Узрост і вага звычайна пераходзяць ад аднаго стадыі да іншай (напрыклад, ад аднаго стадыі да іншай).

Змяненні вагі і узросту звычайна пераходзяць ад аднаго стадыі да іншай (напрыклад, ад аднаго стадыі да іншай).

Узрост і вага звычайна пераходзяць ад аднаго стадыі да іншай (напрыклад, ад аднаго стадыі да іншай).

Змяненні вагі і узросту звычайна пераходзяць ад аднаго стадыі да іншай (напрыклад, ад аднаго стадыі да іншай).

Узрост і вага звычайна пераходзяць ад аднаго стадыі да іншай (напрыклад, ад аднаго стадыі да іншай).

Змяненні вагі і узросту звычайна пераходзяць ад аднаго стадыі да іншай (напрыклад, ад аднаго стадыі да іншай).

Узрост і вага звычайна пераходзяць ад аднаго стадыі да іншай (напрыклад, ад аднаго стадыі да іншай).

Змяненні вагі і узросту звычайна пераходзяць ад аднаго стадыі да іншай (напрыклад, ад аднаго стадыі да іншай).















6.6.6. Мажар мэр үеэнтэйгээ өгөөжөөн мөхөөгчид хэрэгжүүлж өгөхөөс татгалзаж байна.

6.6.6. Мажарид хэрэгжүүлж өгөхөөс татгалзаж өгөхөөс татгалзаж байна. 6.6.6. Мажарид хэрэгжүүлж өгөхөөс татгалзаж өгөхөөс татгалзаж байна.

6.6.6. Мажарид хэрэгжүүлж өгөхөөс татгалзаж өгөхөөс татгалзаж байна. 6.6.6. Мажарид хэрэгжүүлж өгөхөөс татгалзаж өгөхөөс татгалзаж байна.

6.6.6. Мажарид хэрэгжүүлж өгөхөөс татгалзаж өгөхөөс татгалзаж байна.

6.6.6. Мажарид хэрэгжүүлж өгөхөөс татгалзаж өгөхөөс татгалзаж байна.

6.6.6. Мажарид хэрэгжүүлж өгөхөөс татгалзаж өгөхөөс татгалзаж байна. 6.6.6. Мажарид хэрэгжүүлж өгөхөөс татгалзаж өгөхөөс татгалзаж байна.

6.6.6. Мажарид хэрэгжүүлж өгөхөөс татгалзаж өгөхөөс татгалзаж байна.

6.6.6. Мажарид хэрэгжүүлж өгөхөөс татгалзаж өгөхөөс татгалзаж байна. 6.6.6. Мажарид хэрэгжүүлж өгөхөөс татгалзаж өгөхөөс татгалзаж байна.

6.6.6. Мажарид хэрэгжүүлж өгөхөөс татгалзаж өгөхөөс татгалзаж байна.

6.6.6. Мажарид хэрэгжүүлж өгөхөөс татгалзаж өгөхөөс татгалзаж байна. 6.6.6. Мажарид хэрэгжүүлж өгөхөөс татгалзаж өгөхөөс татгалзаж байна.

6.6.6. Мажарид хэрэгжүүлж өгөхөөс татгалзаж өгөхөөс татгалзаж байна.

6.6.6. Мажарид хэрэгжүүлж өгөхөөс татгалзаж өгөхөөс татгалзаж байна.

6.6.6. Мажарид хэрэгжүүлж өгөхөөс татгалзаж өгөхөөс татгалзаж байна. 6.6.6. Мажарид хэрэгжүүлж өгөхөөс татгалзаж өгөхөөс татгалзаж байна.







Монгол Улсын Их Хурлын 2025 оны  
48 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт

МОНГОЛ УЛСЫН ХӨГЖЛИЙН 2026 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

Төсвийн ерөнхийлөн захиргагчийн үр дүн	Хөтөлбөрийн үр дүн	Бодлогын үндэслэл	НЭГ.БҮСҮЧИЛСЭН ХӨГЖЛИЙН БОДЛОГО				Хэмжих нэгж	Шалгуур үзүүлэлт	Үр дүнгийн үзүүлэлт Суурь Түвшин	8	9	Тухайн жилд шардагдах санхүүжилт сая.төг	Санхүүжил- тийн эх үүсвэрийн ангилал	Үндсэн хармуцлагч
			4	5	6	7								
1.1.Бүсүүдийн төвчлэртэй хөгжлийг хөгжсөн болов.	1.1.1.Орон нутгийн эдийн засгийн бие даасан байдлыг нэлэгдүүлсэн болов.	АХ-4.4.1 ЗГҮАХ- 1.3.1.1	1.1.1.1.Эсрэлтийг төрөлжүүлэх, нэлүү өртөг шингэсэн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг дэмжих, гадаадын хөрөнгө оруулалтыг татах, бус нутгийн эдийн засгийн идэвхлэлийг нэмэгдүүлэхэд Ч.Хархорум, Х.Хархорум, С.Орхино, "Хархорум" холбоо байгуулах.	Байгуулагдсан чөлөөт бус	Тоо	-	1	-	-	-	-	-	Шадар сайдын Ахлын алба /Бүсчилсэн хөгжил, онцгой байдлын асуудал эрхэлсэн/	
		ШСБ-3.6.1 ЗГҮАХ- 4.2.2.4	1.1.1.2.Их өсгөлд хиймэл оюун уваанд суурилсан орон зайн төлвөлөгт, гүйцэтгэл, хяналт, удирдлагын нэгдсэн платформыг хөгжүүлэх	Хөгжүүлсэн платформ	Тоо	1	1	2,000.00	500.00	Улсын төсөв	Шадар сайдын Ахлын алба /Бүсчилсэн хөгжил, онцгой байдлын асуудал эрхэлсэн/			
		АХ-4.4.1 ЗГҮАХ- 1.3.1.1	1.1.1.3.Орхино хөндий, "Хархорум" хот байгуулахад шаардлагатай чөлөөлт, бүтээг байгуулалтын байгуулах	Арга хамжээний хэрэгжилт	Хувь	Хувь	-	100	30,707.30	10,707.30	Улсын төсөв	Хархорум хотын захиргагчийн ахлын алба		
		АХ-1.1.13 ЗГҮАХ- 3.3.5.5	1.1.1.4.Палеонтологийн нөөцөд тулгуурлан "Алтан-Сүдэлгана" удирдлагын, орлогыг баягуулах /Дундговь-Цэвэл суурьгай	Барилгын актын гүйцэтгэл	Хувь	Хувь	10	30	1,000.00	200.00	Улсын төсөв	Шадар сайдын Ахлын алба /Бүсчилсэн хөгжил, онцгой байдлын асуудал эрхэлсэн/		
		АХ-8.1.7 ШСБ-1.4.1 ЗГҮАХ- 3.2.2.11, 3.2.2.12	1.1.1.5. Эдийн засгийн хамтын ажиллагааны бүс хөгжүүлэх Ш.Хархорум, С.Орхино, Х.Хархорум, Хүрээдэй, Завь-Уу, Сүхбаатар, Дарь-Бүтэц, Баярж, Байгуулах.	Төслийн хэрэгжилт	Хувь	Хувь	34	100	61,380.00	18,414.00	Гадаадын заал	Шадар сайдын Ахлын алба /Бүсчилсэн хөгжил, онцгой байдлын асуудал эрхэлсэн/		
		АХ-9.2.3 ЗГҮАХ- 1.3.1.4	1.1.1.6.Архангай аймагийн стандарт, эмнэл зүүн хэргийн лабораторийг орхино хөндийн хамт байгуулах	Шинжилсэн багаж, тоног төвөөрөмж	Тоо	Тоо	20	70	100.00	50.00	Улсын төсөв	Шадар сайдын Ахлын алба /Бүсчилсэн хөгжил, онцгой байдлын асуудал эрхэлсэн/		
		АХ-9.2.3 ЗГҮАХ- 1.3.1.4	1.1.1.7.Хөвсгөл аймгийн стандарт, Ш.Хархорум, Х.Хархорум, Хүрээдэй, Завь-Уу, Сүхбаатар, Дарь-Бүтэц, Баярж, Байгуулах	Шинжилсэн багаж, тоног төвөөрөмж	Тоо	Тоо	30	70	100.00	50.00	Улсын төсөв	Шадар сайдын Ахлын алба /Бүсчилсэн хөгжил, онцгой байдлын асуудал эрхэлсэн/		





Төслийн өрөнгүйлэн захирагчийн үр дүн	Хөнгөлбөрийн үр дүн	Бодлогын үндэслэл	Төсөл, арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Хэмжих нэгж	Үр дүнгийн үзүүлэлт			Нийт санхүүжилтийн дүн санх.төг	Тухайн жилд шаардагдах санхүүжилт санх.төг	Санхүүжилтийн эх үүсвэрийн ангилал	Үндсэн харьяалагч
						Суурь түвшинг	Зорилготой түвшинг	Зорилготой дүн санх.төг				
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	
		АХЗ,2.3 ЗГЛАХ- 1.3,6.2 1.4,2.6	1.1.1,8.Хэнтий аймгийн станцарт хамжил зүйн хэлтсийн лабораторийг усны шинжилгээг бүсийн хэмжээнд шинжилгээг болгон хөгжүүлэх	Шинэчилсэн багаж, тоног төхөөрөмж	Тоо	10	70	100,00	50,00	Улсын төсөв	Шаар сайдын Ажлын алба /Бусчилсан хөгжил, онцгой байдлын үйлчилгээний газар	
		ЗГЛАХ- 4.2,4.1, 4.2,4.3	1.1.1,9.Улаанбаатар метрополитан бус дах Уянгуу хотын хөгжлийг удирдах чадварыг бэхжүүлэх техник тусламцааны төслийг хэрэгжүүлэх	Бэлтгэл ажлын хэрэгжилт	Хувь	-	30	7,000.0	2,400.0	Гадаад тусламж	Хат Баяндалат, Барилга, орон сууцнуудтай яам, Нийслэлийн засаг даргын Тамгын газар	
			1.1.1,10.Хөшигийн хөндийн эдийн засгийн чөлөөт бүсийн хэсэгчилсэн үйлдвэр, үйлчилгээний төвүүдийг нарийвчилсан төлөвлөгөө бүтээн байгуулалтын нэгдүгээр үе шатны дэд бүтцийн ТЭЗҮ зураг төсөл боловруулах	Баримт бичгийн тоо	Тоо	0	1	975,8	975,8	Улсын төсөв	Шаар сайдын Ажлын алба /Бусчилсан хөгжил, онцгой байдлын асуудал эрхэлсэн/ Тамгын газар	
		ЗГЛАХ- 1.1.1	1.1.1,11.Хотболдох хуулийн шаардлага хангасан аймаг, нийслэл, орон нутгийн бонд гаргаж, томоохон төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх	Төслийн хэрэгжилт	Хувь	-	50	-	-	Үнэт цаас	Аймаг, Нийслэлийн Засаг даргын Тамгын газар	
		ЗГЛАХ- 3.3,2,27	1.1.1,12.Эрдэнэт хотын доторх авто замын барилга угсралт, шинэчлэлт, өргөтгөл, их засварын ажлыг гүйцэтгэх	Барилгын өргөтгөл гүйцэтгэл	Хувь	20	50	200,000,0	100,000,0	Үнэт цаас, Орон нутгийн төсөв	Орон аймгийн Засаг даргын Тамгын газар	
		ЗГЛАХ- 3.3,3,42	1.1.1,13.Эрдэнэт хотын цахилгаан хангамжийг сайжруулахад шаардлагатай 35 кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станцгар барих	Төслийн хэрэгжилт	Хувь	-	50	200,000,0	50,000,0	Үнэт цаас, Орон нутгийн төсөв	Орон аймгийн Засаг даргын Тамгын газар	
		АХЗ,2,5,17 ЗГЛАХ- 3.3,4,25	1.2.1,1.Лабораторийн мэдээллийн удирдлагын тогтолцоонд нэгтгэн, мэдээллийн нэгдсэн санг хөгжүүлэх	Арга хэмжээний хэрэгжилт	Хувь	75	85	485,00	290,00	Улсын төсөв	Шаар сайдын Ажлын алба /Бусчилсан хөгжил, онцгой байдлын асуудал эрхэлсэн/	
		АХЗ,4,7 ЗГЛАХ- 1.3,2,1, 3,2,2,12	1.3.1,1.Алтанбулаг чөлөөт бүсийг гаалийн төлө хяналтын нэгдсэн системд холбох	Татагдсан шилэн габел суурилагдсан нэмэр	Км	-	3	553,90	553,90	Улсын төсөв	Шаар сайдын Ажлын алба /Бусчилсан хөгжил,	
					Тоо	-	40					



Төслийн ерөнхийлөн захирагчийн үр дүн	Хөтөгчийн үр дүн	Бодлогын үндэслэл	Төсөл, арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Хэмжих нэгж	Үр дүнгийн хэмжээ			Нийт санхүүжилтийн дүн сан.төг	Тухайн жилд шаардагдах санхүүжилт сан.төг	Санхүүжилтийн эх үүсвэрийн ангилал	Үндсэн харуулагч
						Суурь түвшин	Зорилготой түвшин	Тот				
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	
1.3.Чөлөөт бус дахь буцаагдах, бүтээгдэхүүний эргэлтийг сайжруулсан байна.	нэгжийн тоо нэмэгдсэн байна.			Гадлын төлө хяналтын нэгдсэн системийн дэд бүтэцтэй шилжсэн талбайн хэмжээ	Га	-	18				онцгой байдлын асуудал эрхэлсэн/	
1.4.20" минутын эргэлтийг хөгжүүлсэн байна.	1.4.1.Хөгжлийн төлөвлөгөөтэй хот, суурин газрын тоо нэмэгдсэн байна.	АХ-8,17 ЭГУА-3,2,2,11 3,2,2,12	1.3.1,2.Цагааннуур чөлөөт бүсийн зохицуулалт болон гүний худалдаа барилда усралтын ажлыг гүйцэтгэх	Барилгын ажлын ахуйн гүйцэтгэл	Хувь	-	100	4,200.00	4,200.00	Улсын төсөв	Шадар сайдын Ажлын алба /Бүсчилсэн хөгжил, онцгой байдлын асуудал эрхэлсэн/	
1.5.Хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, нийцсэн, тэлш өндөр технологийн үйлдвэрлэлийг чадар нийцдэг болон төхнийн боловсролыг хөгжүүлсэн байна.	1.5.1.Хөгжлийн төлөвлөгөөтэй хот, суурин газрын тоо нэмэгдсэн байна.	АХ-9,1,18 ЭГУА-1,1,1,1	1.4.1,1.Нийрхийн үйлчилгээг 20 минутын эргэлтийн орчин нөхцөлд бүрдүүлэх хотын баримтлалыг хэрэгжүүлэх	Үйл ажиллагааны хэрэгжилт	Хувь	-	50	15,000.00	7,500.00	Улсын төсөв	20 минутын хот Үндэсний хороо	
	1.4.1,2.Хороо, барилд хэмээсэд хэрэгжүүлэх төхмийн бичиг жижиг төслүүдийг орон нутгийн иргэдийн сангийн санхүүжилтээр гүйцэтгүүлсэн тухайн нэгжийн хувийн аж ахуйн нэгжээр гүйцэтгүүлэх	ЭГУА-4,2,4,4	1.4.1,2.Хороо, барилд хэмээсэд хэрэгжүүлэх төхмийн бичиг жижиг төслүүдийг орон нутгийн иргэдийн сангийн санхүүжилтээр гүйцэтгүүлсэн тухайн нэгжийн хувийн аж ахуйн нэгжээр гүйцэтгүүлэх	Тухайн нэгжийн оршин суугаар гүйцэтгүүлсэн төсөвт зэрэг хэмжээ	Хувь	-	30	Орон нутгийн хөгжлийн санд төвлөрөх Дүн	Орон нутгийн хөгжлийн санд төвлөрөх Дүн	Орон нутгийн төсөв	Аймаг, Нийслэлийн Засаг даргын Тамгын газар	
	1.5.1.Мэргэжлийн болон техникийн боловсролд эдийн засгийн тэргүүлэх чиглэл, орон нутгийн хөгжилтэй уялдуулан хослоог ахлын байрны сургалтыг нэвтрүүлэх	АХ-2,1,10 ЭГУА-2,2,2,6	1.5.1.1.Мэргэжлийн болон техникийн боловсролд эдийн засгийн тэргүүлэх чиглэл, орон нутгийн хөгжилтэй уялдуулан хослоог ахлын байрны сургалтыг нэвтрүүлэх	Хослоог ахлын байран дахь сургалтаар суралцаж буй сурагчид	Тоо	50	250	2,685.90	792.00	Улсын төсөв	Боловсролын яам	
	1.5.1.2.Бүсчилсэн хөгжлийн зорилт, тэрхүү чиглэлтэй уялдуулан хослоог ахлын байрны сургалтыг нэвтрүүлэх	АХ-2,1,9 ЭГУА-2,2,2,10	1.5.1.2.Бүсчилсэн хөгжлийн зорилт, тэрхүү чиглэлтэй уялдуулан хослоог ахлын байрны сургалтыг нэвтрүүлэх	КОССЭН хөгжүүлж буй коллеж	Тоо	-	2	1,350.00	300.00	Улсын төсөв	Боловсролын яам	
	1.6.1.1.Тавантолгой 450 МВт-ын дулааны цахилгаан стэнц барих төслийг хэрэгжүүлэх	АХ-4,2,34 ШБ-2,1,1 1,3,4,4	1.6.1.1.Тавантолгой 450 МВт-ын дулааны цахилгаан стэнц барих төслийг хэрэгжүүлэх	Төслийн хэрэгжилт	Хувь	20	50	2,286,904.40	689,071.32	Гадаад, Дотоодын ордууд	Эрчим хүчний яам	
	1.6.1.2.Эрдэнэбрангийн 90 МВт-ын усан цахилгаан станц барих төслийг хэрэгжүүлэх	АХ-4,2,36 ШБ-3,2,1 ЭГУА-1,3,2,4	1.6.1.2.Эрдэнэбрангийн 90 МВт-ын усан цахилгаан станц барих төслийг хэрэгжүүлэх	Барилгын ажлын гүйцэтгэл	Хувь	15	70	776,446.00	178,000.86	Улсын төсөв, Гадаадын зээл	Эрчим хүчний яам	

Төслийн ерөнхийлөн захиралчийн үр дүн	Хөтөлбөрийн үр дүн	Бодлогын үндэслэл	Төсөл, арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Хэмжих нэгж	Ур дүнгийн үзүүлэлт	Нийт санхүүжилтийн дүн сая.төг	Тусгай жилд шаардалзах санхүүжилт сая.төг	Санхүүжилтийн эх үүсвэрийн ангилал	Үндсэн харуулагч
1	2	3	4	5	6	7	8	9	11	12
1.6.Цахилгаан эрчим хүчний дотоодын үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх хөрөнгийн хангамж хангаан байна.	1.6.1.Цахилгаан эрчим хүч үйлдвэрлэх үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх хөрөнгийн хангамж хангаан байна.	АХ-4.2.34 ЗГҮАХ- 1.3.3.4.6	1.6.1.3.Далайзадгад 50 МВ-ын цахилгаан станц барих төслийг хэрэгжүүлэх.	Төслийн хэрэгжилт	Хувь	5	473,000.00	142,000.00	Орон дотроос төсөв	Эрчим хүчний яам
		АХ-4.2.34 ЗГҮАХ- 3.3.3.4.9	1.6.1.4.Төвийн бүсийн наргасан сулжээнд ажиллах 100 МВ-ын "Усан цэнэгт цахилгаан станц" төслийг хэрэгжүүлэх	Төслийн хэрэгжилт	Хувь	-	650,628.00	65,062.80	Гадаадын зээл	Эрчим хүчний яам
		АХ-4.2.34 ЗГҮАХ- 2.4.3.4	1.6.1.5.Дархануул дагууны цахилгаан станц хүрч уур тэжээлийн усны шулан холбогч шинэчлэх	Барилгын ажлын гүйцэтгэл	Хувь	-	3,600.00	1,440.00	Улсын төсөв	Эрчим хүчний яам
		АХ-4.2.35 ШСБ-2.1 ЗГҮАХ- 3.3.3.2.9	1.6.1.6.Төвийн цахилгаан станц 220 МВ-ын хүчээр суурилуулах үйлдвэрлэлийн агаарын шуугамыг барьж "Цагаан суварга" ДАД станцыг өргөтгөх	Төслийн хэрэгжилт	Хувь	-	98,389.20	4,919.46	Гадаадын зээл	Эрчим хүчний яам
		АХ-4.2.34 ШСБ-2.1.7 ЗГҮАХ- 3.3.1.5	1.6.1.7.Багануур-Чойр чиглэлийн 220 кВ-ын 2 хэлхээ 188 км урт цахилгаан дамжуулах агаарын шуугамыг барьж, Чойр Дэд станцыг суурилуулах	Төслийн хэрэгжилт	Хувь	10	114,945.80	28,988.12	Гадаадын зээл	Эрчим хүчний яам
		АХ-4.2.35 ШСБ-2.1 ЗГҮАХ- 3.3.3.4.0	1.6.1.8.Төвийн цахилгаан дамжуулах агаарын шуугамыг барьж, Чойр Дэд станцыг суурилуулах	Төслийн хэрэгжилт	Хувь	5	109,798.68	21,959.74	Гадаадын хөрөнгө оруулалт	Эрчим хүчний яам
		АХ-4.2.35 ШСБ-2.1 ЗГҮАХ- 3.3.3.4.0	1.6.1.9.Чойр-Сайншанд чиглэлийн 220 кВ-ын 2 хэлхээ 220.04 км урт цахилгаан дамжуулах агаарын шуугамыг барьж, Чойр Дэд станцыг суурилуулах	Төслийн хэрэгжилт	Хувь	40	195,373.91	92,686.96	Гадаадын зээл	Эрчим хүчний яам
		АХ-4.2.35 ШСБ-2.1 ЗГҮАХ- 1.3.2.4	1.6.1.10.Сүхбаатар-Чөлөөт хотын цахилгаан дамжуулах агаарын шуугамыг барьж, Чойр Дэд станцыг суурилуулах	Төслийн хэрэгжилт	Хувь	5	47,982.30	9,596.46	Улсын төсөв	Эрчим хүчний яам
